



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 8/17

Шивээговь сум

Б.Даваадолгорын цалинг шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 25 дугаар “Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоолын 2 дугаар хавсралт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн A/122 дугаар “Төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай” тушаалыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ НЬ:**

1. Сумын 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Бүдээбатын Даваадолгорын албан тушаалын үндсэн цалинг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 1,182,507 (нэг сая нэг зуун наян хоёр мянга таван зуун долоо) төгрөгөөр шинэчлэн баталсугай.

2.Б.Даваадолгорын албан тушаалын үндсэн цалинг ТҮБД-5 зэрэглэлийн 1,182,507 (нэг сая нэг зуун наян хоёр мянга таван зуун долоо) төгрөг, Тэргүүлэх мэргэжлийн зэргийн нэмэгдэл 15%, Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 25%, Орон нутагт ажилласны нэмэгдлийг 15 хувиар тус тус үндсэн цалингийн хувиар бодож, сар бүр олгохыг 3 дугаар цэцэрлэгийн нягтлан бодогч (Д.Билэгсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ